

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ  
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 27-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БОЛОН  
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРООДЫН ХАМТАРСАН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БОЛОН ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООДЫН  
ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
АГУУЛГА**

2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 - 3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4 - 14

1. *“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль, тогтоолд бүхэлд нь тавьсан хоригийг Монгол Улсын Их Хурал хүлээн авсантай холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийн хууль болон дагалдах хууль, тогтоолыг хэлэлцэх асуудлаар санал боловсруулах үүрэг бүхий/*

8 - 14

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Ёс зүй, дэгийн болон Хууль зүйн байнгын хороодын 11 дүгээр сарын 27-  
ны өдөр /Лхагва гараг/-ийн хамтарсан хуралдааны  
товч тэмдэглэл**

Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Б.Баярбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хамтарсан хуралдаанд ирвэл зохих нийт 35 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 54.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 34 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.*

*Томилолттой: Х.Баасанжаргал, Д.Рэгдэл, П.Сайнзориг;  
Чөлөөтэй; Н.Алтанхуяг, Э.Бат-Амгалан, Б.Бат-Эрдэнэ, Д.Бум-Очир,  
Л.Мөнхбаатар, Да.Цогтбаатар, С.Эрдэнэболд;  
Эмнэлгийн чөлөөтэй: У.Отгонбаяр;  
Тасалсан: С.Одонтуяа.*

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Ч.Лодойсамбуу нарын тавьсан асуултад Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Б.Баярбаатар, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж нар хариулж, тайлбар хийв.

***Нэг. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл*** /Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль, тогтоолд бүхэлд нь тавьсан хоригийг Монгол Улсын Их Хурал хүлээн авсантай холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийн хууль болон дагалдах хууль, тогтоолыг хэлэлцэх асуудлаар санал боловсруулах үүрэг бүхий/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын ажлын албаны Ёс зүй, дэгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Наранцэцэг, референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Б.Баярбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Ж.Алдаржавхлан нарын тавьсан асуултад Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Б.Баярбаатар, Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат, Б.Энхбаяр, Д.Ганмаа нар үг хэлэв.

**Б.Баярбаатар:** “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 9

Бүгд: 20

55.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Ж.Алдаржавхлан, Д.Энхтуяа нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 70.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

*Уг асуудлыг 13 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хамтарсан хуралдаан 22 минут үргэлжилж, ирвэл зохих нийт 35 гишүүнээс 23 гишүүн хүрэлцэн ирж, 65.7 хувийн ирцтэйгээр 13 цаг 56 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЁС ЗҮЙ, ДЭГИЙН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

Б.БАЯРБААТАР

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

Д.ЦОГТБААТАР

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААН ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр, Лхагва гараг  
Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхим  
13 цаг 34 минут

### ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БОЛОН ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Б.Баярбаатар:** Эрхэм Улсын Их Хурлын гишүүддээ өдрийн мэнд хүргэе.

Хурлын ирцийг Та бүхэнд танилцуулъя.

Өнөөдөр Улсын Их Хурлын Ёс зүй, дэгийн байнгын хороо болон Хууль зүйн байнгын орооны хамтарсан хурал хуралдахад бэлэн боллоо.

Ёс зүй, дэгийн байнгын хорооноос Баярмагнай Баярбаатар ирсэн, Аюушийн Ариунзаяа ирсэн, Хүрэлбаатарын Баасанжаргал чөлөөтэй, Жамбын Батсуурь ирсэн, Дуламын Бум-Очир чөлөөтэй, Даваасамбуугийн Ганмаа ирсэн, Болдын Жавхлан ирсэн, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан ирсэн, Чулуунбилэгийн Лодойсамбуу ирсэн, Ганбатын Очирбат ирсэн, Дүгэрийн Рэгдэл чөлөөтэй, Бадарчийн Хэрлэн ирсэн, Доржзовдын Энхтуяа ирсэн байна.

Хууль зүйн байнгын хорооноос Д.Цогтбаатар гишүүн ирсэн байна, Ж.Алдаржавхлан гишүүн ирсэн байна, Норовын Алтанхуяг гишүүн чөлөөтэй, Э.Бат-Амгалан гишүүн ирээгүй байна, Халтмаагийн Баттулга гишүүн ирсэн байна, Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн гадаад томилолттой, М.Нарантуяа-Нара гишүүн ирсэн байна, О.Номинчимэг гишүүн ирсэн байна., Б.Пүрэвдорж гишүүн ирсэн байна, П.Сайнзориг гишүүн гадаад томилолт гэсэн байна. Ц.Сандаг-Очир гишүүн ирсэн байна, Х.Тэмүүжин гишүүн ирсэн байна, Г.Уянгахишиг гишүүн ирсэн байна, Да.Цогтбаатар гишүүн чөлөөтэй, Б.Энхбаяр гишүүн ирсэн байна, С.Эрдэнэболд одоогоор шалтгаангүй байна.

Ингээд хурлын ирц 55.9 хувьтай байна.

Хэлэлцэх асуудлыг Та бүхэнд танилцуулна.

“Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсантай холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай болон дагалдах хуулиудыг хэрхэн хэлэлцэх талаар санал боловсруулах үүрэг бүхий хамтарсан ажлын хэсгийг байгуулах тухай” Байнгын хорооны хамтарсан тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбоотой санал, асуулттай гишүүд байна уу?  
Ч.Лодойсамбуу гишүүн, Б.Энхбаяр гишүүн. Асуулт санал тасаллаа.

Б.Энхбаяр гишүүн.

**Б.Энхбаяр:** Хамтарсан Байнгын хорооноос ажлын хэсэг гаргаж энэ асуудалд дүгнэлт гаргаж байгаад нухацтай хандъя гэдэг энэ саналыг дэмжиж байна.

Нэг ийм юм Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авах үед яригдаад байсан юм.

Нэг удаагийн дэг. Нэг удаагийн асуудлаар тийм дэг хийж болох ч юм шиг.

Дэгийн байнгын хороо өөрөө саналаа бэлтгээд, тэгээд түүгээр хэлэлцээд нэг удаагийн шинж чанартай үйлчлэх ч юм шиг нэг ийм агуулга яриад байсан.

Тэгэхээр энэ бүр дэгийн хуульд өөрчлөлт оруулах чиглэлд байна уу, эсвэл энэ ажлын хэсэгт дүгнэлтээ гаргаж байгаад саналаа бэлтгэх учраас мэдээж магадгүй дараа нь асуугдах асуултыг би асуух гээд байж магадгүй.

Тэгэхдээ яах вэ нэгэнт ажлын хэсэг байгуулагдах гэж байгаа учраас гишүүд ч тэр, олон нийт ч тэр ойлголт өгвөл.

Цаг хугацааны хувьд ажлын хэсэг энэ долоо хоногтоо ажиллаад дүгнэлтээ гаргана. Магадгүй ирэх долоо хоногт бид Дэгийн хуулийг түргэвчилсэн горимоор хэлэлцэнэ гэхээр төсвийн хүлээж авсантай холбоотой хоёр дахь гэж хэлнэ үү, эхнийх гэж хэлнэ үү, тэр хувилбаруудын аль нэг.

12 сарын 05-наас хойш яригдах гээд байх шиг байна уу, үгүй юу. Цаг хугацааны хувьд.

Тэгэхээр энэ ондоо багтаад бид боломжит богино хугацаанд л төсвөө баталж авахгүй бол. Тийм ээ. Цаашаа хүлээгдэж байгаа тийм цаг хугацааны хүчин зүйлүүд байгаа. Орон нутгууд төсвөө батлах ёстой байгаа.

Тэгэхээр энэ юмнуудыг яаж харж байгаа юм болоо гэдэг. Би чинь Тамгын газраас асуух уу? Яах юм бол?

**Б.Баярбаатар:** Б.Баасандорж дарга.

**Б.Баасандорж:** Б.Баасандорж. Б.Энхбаяр гишүүний асуултад хариулъя.

Одоо ажлын хэсгийг хоёр Байнгын хороо хамтарч хуралдаад ажлын хэсэг байгуулагдах юм бол гишүүд маань яг бүрэн эрхийнхээ хүрээнд ажлын хэсгээс эцсийн шийдвэрийг гаргана.

Яг хоригийг ямар журмаар, ямар дэгээр, яаж хэлэлцэх вэ гэдэг.

Тамгын газрын зүгээс гишүүддээ зөвлөхөд Дэгийн хуулийн 16 дугаар зүйлд, тэр дундаа 16 дугаар зүйлийн 16.3 дээр энэ хуулийн 16.1-д заасан хуралдааны дэгийг нэг удаа зөвхөн тухайн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд мөрдөнө гэж байгаа юм.

Үндсэн хууль дээр юу гэж байсан байдаг вэ гэхээр яг Улсын Их Хурлын үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.

Зүгээр яг энэ асуудалтай холбоотой өмнө нь манай 8 удаагийн парламентад ямар туршлага байсан юм бэ гэж үзэхээр яг өнгөрсөн парламентын үед Цэцийн дүгнэлттэй холбоотой Сонгуулийн хуулийн эцсийн хэлэлцүүлгийг хийхэд дэг дээр нарийвчилсан зохицуулалт байгаагүй. Яг тэр дээр Дэгийн байнгын хороо хуралдаад Их Хурал руу асуудал оруулаад, олонхоороо яг энэ асуудал дээр эцсийн хэлэлцүүлгийг дахин хийе гэдэг шийдвэр гаргасан юм билээ.

Гэхдээ Б.Энхбаяр гишүүн ээ, тэр нь хууль байгаагүй, тогтоол байгаагүй.

Одоо бол бид сая 7 сарын 01-нээс хэрэгжиж эхэлсэн энэ дэгийн хуулийг харахаар яг тухайн асуудлыг нэг удаа зөвхөн хэлэлцэхэд тухайн асуудлыг шийдвэрлэнэ.

Тэгээд энэ бол дэг. Үндсэн хуулиараа Улсын Их Хурлын дэгийг хуулиар тогтооно шүү гээд тогтоочихсон.

2007 оноос яг энэ Үндсэн хуулийн дагуу. Дэг өмнө нь Их Хурлын тогтоол байсан. 2007 оноос хойш хууль болсон. Дандаа хууль.

Тэгэхээр үүнийг хуулиар тогтоох ёстой гэж үзэж байгаа.

Таны хоёр дахь асуудлын хувьд Монгол Улсын Ерөнхийлөгч Үндсэн хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Их Хурлын баталсан хууль дээр хориг тавьсан. Өөрөөр хэлбэл төсөв дээр хориг тавьсан. Хүчин төгөлдөр болсон Төсвийн хуулийг үндэслээд орон нутаг, аймаг, нийслэл төсвөө ярьдаг.

Тэгэхээр үндэслэх хууль маань өөрөө хоригтой байгаа учраас дагаад тэр нэгжийн хуулиуд маань, төсвийн хууль дээр байдаг аймаг, нийслэл 12 сарын 05-нд төсвөө батлах ёстой гэж ярьдаг.

Тэгээд тэр хуулиуд маань ч гэсэн тодорхой хугацаанд түдгэлзэх юм болов уу гэж үзэж байгаа.

Гэхдээ үүнийг ажлын хэсэг дээр ярилцах байх. Гишүүд. Тийм ээ.

**Б.Баярбаатар:** Ч.Лодойсамбуу гишүүн.

**Ч.Лодойсамбуу:** Надад хэлэлцэх асуудалтай холбоотой гэж байгаа учраас надад энэ хэлэлцэх асуудалтай холбоотой нэг асуулт бүхий санал байна.

Яах вэ манай Байнгын хорооны хүрээний асуудал биш л дээ.

Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн тухай асуудал яригдаж байгаа.

Засгийн газраас яаралтайгаар орж ирж байгаа гэж ойлгож байгаа. Дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйл дээр Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэх гээд ийм зүйл байгаа.

Энэ дээр Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслээд Ерөнхий сайд Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга хуулийн төслийг чуулганаар яаралтай хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд оруулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ гэж байгаа юм.

Тэгэхээр энэ нь өөрөө ямар сэдвээр яаж яаралтайгаар хэлэлцэх вэ гэдэг хүрээ хязгаарыг тогтоочихсон юм болов уу гэж би буруу ойлгоод байна уу? Энэ хүрээ хязгаар тогтоочихсон байх шиг байна.

Тэгэхээр үүнийг тойруулаад. Ер нь Засгийн газраас яаралтайгаар гээд гээд зөндөө л хуулийн төслүүд оруулаад явдаг жишиг тогтчихсон.

Тэгэхээр юуг яаралтай хэлэлцэх вэ гэдгийг дэгийн хууль дээрээ заачихсан байхад үүнийг тойроод явж байгаа тохиолдолд би ажиглаж байгаагаар тойроод явж байгаа харагдаад байх юм.

Тэгэхээр хэдийгээр манай асуудал биш ч гэсэн энэ дэг сахиулах үүрэг бүхий Байнгын хороо. Үүнийг нэг хэлэлцэх нь зөв юм болов уу. Үүнийг ингэж санал оруулж дүгнэлт гаргах хэрэгтэй юу, хэрэггүй юу гэдэг ийм санал бүхий асуулт байна.

**Б.Баярбаатар:** Ойлголоо. Хэдүүлээ наад талаар чинь дараа нь тусгайлан өөрсдийнхөө Байнгын хороон дээр ярилцах нь зөв байх. Нэг.

Хоёрт, яг энэ хажуу талын танхимд Төрийн байгуулалтын байнгын хороо энэ улс төрийн намын хуультай холбоотой хэлэлцүүлэг эхлэх гэж байна.

Энэ дээр Улсын Их Хурлын гишүүнийхээ хувьд та орж асуулт санал асуух хуулиар олгогдсон эрх байгаа гэдгийг хэлье.

Ингээд хэлэлцэх асуудалтай холбоотой асуулт санал хэлж дууслаа. Хэлэлцэх асуудлаа баталъя. /алх цохив/



Хэлэлцэх асуудалдаа оръё.

---

**Нэг. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл**  
/Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль, тогтоолд бүхэлд нь тавьсан хоригийг Монгол Улсын Их Хурал хүлээн авсантай холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийн хууль болон дагалдах хууль, тогтоолыг хэлэлцэх асуудлаар санал боловсруулах үүрэг бүхий/

---

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд бүхэлд нь тавьсан хоригийг Улсын Их Хурал 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр хүлээж авсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн тухай болон дагалдах хуулиудыг хэрхэн хэлэлцэх талаар санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах манай хоёр Байнгын хорооны хамтарсан тогтоолын төслийг хэлэлцэж эхэлнэ.

Тогтоолын төслийг Та бүхэнд тараасан.

Тэгэхдээ Та бүхэнд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийг үндэслэн Ёс зүй, дэгийн болон Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль тогтоолд бүхэлд нь тавьсан хоригийг Монгол Улсын Их Хурал хүлээн авсантай холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон дагалдах хууль тогтоолыг хэлэлцэх асуудлаар санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Ч.Лодойсамбуу

Улсын Их Хурлын гишүүн

Гишүүдэд:

А.Ариунзаяа

Улсын Их Хурлын гишүүн

Д.Ганмаа

Улсын Их Хурлын гишүүн

М.Нарантуяа-Нара

Улсын Их Хурлын гишүүн

П.Сайнзориг

Улсын Их Хурлын гишүүн

---

Ц.Сандаг-Очир	Улсын Их Хурлын гишүүн
Х.Тэмүүжин	Улсын Их Хурлын гишүүн
Г.Уянгахишиг	Улсын Их Хурлын гишүүн
Б.Хэрлэн	Улсын Их Хурлын гишүүн

2.Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагаас мэргэжлийн хүмүүсийг оролцуулж ажиллуулахыг ажлын хэсгийн ахлагч Ч.Лодойсамбуу зөвшөөрсүгэй гэсэн тогтоолын төсөл байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуулт, саналтай гишүүд байна уу? Үг байна. Асуултын дараа болно.

Алдарт А.Ариунзаяа гишүүн, Ж.Алдаржавхлан гишүүнээр тасалъя. А.Ариунзаяа гишүүн.

**А.Ариунзаяа:** Алдарт А.Ариунзаяа гишүүн гэхээр гайхлаа шүү дээ.

Ийм хурдан алдарт хүрч. Юу вэ. Гайхалтай хэллээ. Тийм ээ.

Дарга аа, энэ яаралтай асуудал учраас цаг хугацаа тавих юм бол илүү зохистой болов уу гэж бодож байна. Ажлын хэсгийг ажиллах цаг хугацааны хязгаарыг нь бас тогтоолын төсөлдөө оруулж өгсөн нь зүйтэй гэж үзэж байна.

**Б.Баярбаатар:** Санал хэллээ. Ж.Алдаржавхлан гишүүн.

**Ж.Алдаржавхлан:** Би сая Ч.Лодойсамбуу гишүүнээс асаагаад сууж байсан юм.

Энэ чинь дэг дээр ажиллах чинь ажлын хэсэг юм байна. Тийм ээ.

Би эртээд Д.Цогтбаатар даргад нэг санал хэлсэн шүү дээ. Төсвийн ажлын хэсэг дээр би орно шүү гэж. Тэр төсөв. Тэр дээр оруулж өгөөрэй.

Хэд хэдэн ажлын хэсгийг харахад ер нь та хэд болж өгвөл хуульч нэлээн туршлагатай улсууд сонгосон юм шиг байна гэж би ойлголоо.

Бүлгээс ирсэн санал уу? Эсвэл яаж байгуулсан юм. Ямар ч байсан дэгээс тусдаа явна гэж ойлгох уу? Энэ ажлын хэсгийн ажил чинь төсвөөс. Тийм ээ.

Хоёрдугаарт, орон нутгийн төсөв чинь төсвийн хуулиараа хугацаатай байгаа.

Тэгэхээр Төсвийн тухай хуульд дахиад өөрчлөлт орж таарах нь байна шүү дээ.

Тэгэхдээ нэгэнт өөрчлөлт оруулж байгаа юм чинь бас нэг тийм дараа ашиглахуйц хэмжээний өөрчлөлт оруулмаар байгаа юм. Одоо өөрчлөлт орж таарна шүү дээ.

12 сарын 05-ны дотор баталсан байх ёстой гэдэг хатуу заалт байгаа. Түүнийгээ хөндөж байгаа бол эргээд дараа нь ийм нөхцөл байдал үүсэх юм бол тэр асуудлыг шийдвэрлэх тийм давхар зорилготой өөрчлөлтийг хийгээсэй л гэж хүсэж байна. Ажлын хэсгийнхэн. Тийм саналыг оруулж ирээсэй л гэж хүсэж байна.

Миний асуулт бол эхнийх нь байгаа.

**Б.Баярбаатар:** Д.Цогтбаатар гишүүний микрофоныг.

**Д.Цогтбаатар:** Энэ дээр би таны юуг санаж байгаа. Энэ дээр бүлгийн даргатай энэ асуудлыг ярина. Таныг оруулъя гээд ярья. Тийм. Энэ биш.

Энэ дээр бүлгийн удирдлагатай ярьж байгаад оруулж ирж байгаа.

**Б.Баярбаатар:** Энэ дээр нэмэлт мэдээлэл өгөхөд яах вэ, өнөөдөр дэгийн хууль, Их Хурлын тухай хуулиар манай Байнгын хороонд хамаарах хүрээний асуудал байгаа юм. Ёс зүй, дэгийн байнгын хорооны хүрээнд.

Тэгэхдээ өнөөдөр энэ төсөв. Тэгээд төсөвт бүхэлд нь тавигдсан хориг чухал асуудал.

Энд бид нэг Байнгын хороогоороо хандахаас илүүтэйгээр Хууль зүйн байнгын хороотойгоо хамтарсан байдлаар ажлын хэсэг байгуулъя.

Ажлын хэсэгт ажиллах боломжийг нь олгоё.

Ажлын хэсэг гаргаад ирсэн саналыг эргээд Ёс зүй, дэгийн байнгын хороо хэлэлцэж, тэндээс гарсан санал, дүгнэлтийг Улсын Их Хуралд танилцуулъя гэсэн ийм чиг үүрэгтэйгээр өнөөдрийн ажлын хэсэг орж ирж байгаа шүү гэдгийг давхар мэдээлээд хэлье.

Хугацаа тавих нь зөв байх. А.Ариунзаяа гишүүний хэлж байгаагаар.

Бид одоогоор харж байгаагаар өнөөдөр энэ ажлын хэсэг их богино хугацаанд яаралтай ажиллах зайлшгүй шаардлага байгаа.

Одоо ингээд 15.00 цагаас ажлын хэсгийн хурал байгуулагдсан тохиолдолд ажлын хэсгийн хурлаа хуралдуулаад, маргааш бүтэн ажиллаад, нөгөөдөр Ёс зүй, дэгийн байнгын хорооны хурлыг товлож танилцуулах ийм төлөвлөгөө байж байна.

Санал хэлэх гишүүд. Г.Очирбат гишүүн, Б.Энхбаяр гишүүн, Д.Ганмаа гишүүнээр тасаллаа. Г.Очирбат гишүүн.

**Г.Очирбат:** Өдрийн мэнд хүргэе.

Их Хурлын Тамгын газрынхан ажлын хэсэг дээрээ нэлээн анхааруулж аж ажиллаарай гэж хэлэх гэсэн юм.

Чуулганы дэгийн тухай хуулийн 90.9 байгаа. Хялбаршуулснаар бид нар ингээд хурдан хугацаанд явуулъя гэж байвал үүнийгээ бариад явчихвал хаана хаанаа их амар болчихно. Тийм биз. 90.9. Дэгийн тухай хуулийн.

Яг одоо Б.Баасандорж даргын хэлж байгаагаар болохоор бид 16-г бариад явъя. 16.3-аар ажлын хэсэг гаргаад явчихъя гэж байгаа юм байна шүү дээ. Тийм ээ.

Хэрвээ ингэж явах юм бол нэлээн тийм задаргаатай, деталь руу орсон, цаг хугацаа авсан ийм юм болох болов уу гэж харж байгаа юм.

Дэгийн тухай хуулийн 90.9-өөр явах юм бол нөгөө хуучин байсан ажлын хэсэг нь Байнгын хороон дээрээ хэлэлцээд явчих ийм боломж бололцоонууд байгаа шүү гэж харж байна.

Тэгээд ажлын хэсгийнхэндээ амжилт хүсье. Нийгэмдээ нэлээн асуудал үүссэн. Төсөвтэй холбоотой байр сууриуд илэрхийлэгдэж байсан.

Тэгээд үүнтэй тал талынх нь саналыг аваад нэлээн тийм мэргэжлийн ажлын хэсэг оруулсан юм байна.

Тэгээд Ч.Лодойсамбуу гишүүн ахлах юм байна. Тэгээд та бүхэндээ амжилт хүсье.

Тамгын газрынхан нь нэлээн хамтарч ажиллаж туслаарай гэж хэлэх гэсэн юм.

**Б.Баярбаатар:** Б.Энхбаяр гишүүн.

**Б.Энхбаяр:** Ерөнхийлөгчийн хоригтой холбоотой миний бие Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд хэлсэн үгэндээ энэ асуудал дээр нэгдүгээрт, улс төрийн, хоёрдугаарт, эрх зүйн дүгнэлт Улсын Их Хурал, Засгийн газар аль аль нь өгөх ёстой гэдэг ийм үгийг хэлж байсан.

Тэр ч утгаараа ажлын хэсгийн түвшинд дэгийг хийхдээ энэ хүчин зүйлийг анхаарч ажиллаасай гэсэн ийм хүсэлт байна.

Сая Тамгын газраас өгсөн тайлбарын дагуу Монгол Улсынхаа Үндсэн хуульд нийцүүлж дэгийн хуульдаа өөрчлөлт оруулах замаар, өөрөөр хэлбэл нэг удаагийн тогтоол хэлбэрээр биш хуулиар дэгээ зохицуулна гэсэн Үндсэн

хуулийнхаа заалтад нийцүүлж дэгээ боловсруулах нь зүйтэй болов уу гэсэн ийм саналтай байна.

Ингэхдээ мэдээж бусад улс орнуудын хүчин зүйлүүдийг тооцох ёстой.

Хэрэв бид ардчилсан Европын загвар болсон парламентын жишгүүдийг тооцох юм бол энэ дээр улс төрийн үр дагавар ярьдаг юм.

Өөрөөр хэлбэл хэрэв тухайн төсвөө батлуулж чадаагүй бол энэ дээр итгэл үзүүлэх асуудлыг парламент бас ярьдаг тийм жишигтэй.

Хоёрдугаарт, төсөв хэлэлцэхэд ялангуяа Европын парламентууд заавал Сангийн сайдын саналыг авдаг. Энэ бол Засгийн газрыг төлөөлж байгаа төсвийн бодлогоо хариуцаж байгаа учраас.

Тэгэхээр нэгэнт Үндсэн хуульд Засгийн газрын өөрийнх нь онцгой бүрэн эрхэд улсын төсвийг парламент руу оруулах гэдэг тэр эрх нь гүйцэтгэх эрх мэдлийн өөрийнх нь үндсэн хуульчилсан эрх байгаад байгаа юм. Үүнийг нь заавал харгалзах ёстой буюу энэ төлөөллийг хангах этгээд нь би Сангийн сайд болов уу гэж бодоод байгаа юм.

Тэгэхээр Сангийн сайдын оролцоо, саналыг авдаг байх ёстой.

Тэгэхдээ энэ өргөн баригдаж байгаа төсөл биш байгаад байгаа. Парламентаас батлагдчихсан учраас “Сангийн сайд зөвшөөрсөн” гэж хэлбэл болохгүй болчих байх. “Сангийн сайдын саналыг авна” гэсэн хэлбэр ажлын хэсэг дээр харин байж болох байх. Энэ дээр Сангийн сайд ямар байр суурьтай байна вэ гэдгийг нь сонсож явах талаасаа.

Хоёр дахь гол онцлог бол цаг хугацааны хувьд өргөн баригдаж байгаа шинэ төсөлтэй харьцуулбал тэр хэлэлцүүлгийн хугацаанууд, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, аудитын байгууллагуудын энэ дүгнэлт, саналуудыг арай хураангуй товчилсон цаг хугацааны хувьд мөчлөгтэй ийм хэлбэрээр оруулах шаардлага үүсэх байх.

Өөрөөр хэлбэл, тэр байгууллагуудын дүгнэлт, саналыг огт авахгүйгээр яах уу, бас авдаг байх уу гэдэг ийм хувилбар гараад байгаа юм.

Гуравт нь, үүнтэй холбоотойгоор төсвийг хэлэлцүүлэх үеэр их олон удаа яригдсан. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн энэ санал, зөвлөмжийг ер нь чуулганы нэгдсэн хуралдаан болон Байнгын хорооны хуралдаанд эрх зүйн ямар хүчин чадалтай хэлбэрээр авч үзэх вэ гэдэг асуудал олон гишүүдийн үгнээс гараад байсан юм.

Энэ бол ер нь цааш цаашдын парламентын шийдвэр гаргахад нөлөөлөх зүйл юм шиг байгаа юм.

Тийм учраас үүнийг болж өгвөл бас нэг илүү тодорхой болгох талаас нь ажлын хэсэг авч үзээсэй гэсэн нэг ийм санал байгаа юм.

Магадгүй нэгэнт Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс өгч байсан зөвлөмжид туссан Монгол Улсын Ерөнхийлөгчөөс энэ шаардлага хангагдахгүй бол дахиж хориг тавихыг үгүйсгэхгүй гэдэг энэ байр сууриуд дээр үндэслээд ажлын дэд хэсгийг. Би төсвийн ажлын дэд хэсгийг яриад байгаа шүү.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөр өөрөөр нь ахлуулж явах нь магадгүй зөв ч байж магадгүй юм шиг санагдаад байгаа юм.

Өөрөөр хэлбэл Засгийн газраас биш. Дэд ажлын хэсгийг нь яриад байгаа шүү. Дэд ажлын хэсгийг нь Сангийн яам голчлоод яваад байдаг. Саяын нөхцөл байдал бол.../минут дуусав/

**Б.Баярбаатар:** Д.Ганмаа гишүүн санал хэлнэ.

**Д.Ганмаа:** Би бараг хэлэхгүй ч байж болохоор. Санал давхардчихлаа.

Хэлэх гэсэн зүйл бол одоо энэ ажлын хэсэг дээр нэмэлт бүрэлдэхүүн байдлаар яг саяын Б.Энхбаяр гишүүний хэлж байсан хүмүүс бүрэлдэхүүнээс оруулах боломжтой эсэх. Оруулъя гэсэн санал. Дээрээс нь нэмээд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас ч юм уу шаардлагатай бүрэлдэхүүнийг оролцуулах боломжтой юу гэдэг талаар ярих гэсэн байсан.

**Б.Баярбаатар:** Энэ төсөвт тавьсан хоригтой холбоотой дэгийн тухай хуулиар зохицуулаагүй асуудал. Хориг тавьсан учраас.

Цаашид ер нь яаж хэлэлцэх юм бэ гэдэг. Тэгээд энэ саналыг боловсруулах ажлын хэсэг.

Гишүүдийн хэлж байгаа санал дотор төсөвтэй холбоотой, төсөв хэлэлцэх үеэр байгуулагдах ажлын хэсэг, дэд ажлын хэсэгтэй холбоотой саналууд гарч байна.

Үүнийг дараа нь тэр төсвийн том ажлын хэсэг байгуулагдаад тэр агуулга дотроо яриад явах нь зөв болов уу гэж бодож байна.

Тэгэхдээ Тамгын газар гишүүдийн хэлсэн саналуудыг тусгаж аваад ажлын хэсэгт туслан зөвлөх хэлбэрээр ажиллах учраас энэ дээрээ анхаарч ажиллах нь зүйтэй гэж бодож байна.

Ингээд гишүүд санал хэлж дууслаа. /алх цохив/

---

Энэ тогтоолын 3 дугаар заалт дээр ажлын хэсэг яаралтай ажиллаж Ёс зүй, дэгийн байнгын хорооны хуралдаан танилцуулахыг үүрэг болгосон нэг тийм заалт нэмэх нь зөв болов уу гэж бодож байна. Хугацаа тавиад.

Яах вэ, одоо яг дүгнэлт гарахдаа ажлын хэсгээ бид хамтраад гаргачихсан.

Дүгнэлт гарахдаа бид дэгийн хуулиараа манай Байнгын хорооноос дүгнэлт гарч байгаа. Тийм.

Үндсэндээ бид Хууль зүйн байнгын хорооноосоо туслалцаа авч байгаа хэлбэр байхгүй юу. Энгийн үгээр илэрхийлбэл.

Бүртгэлийн санал хураалт явуулна. Одоо тогтоолын төслийг батлах ёстой. Хамтарсан байнгын хорооны хурлаар танилцуулъя гэж байна шүү. Бүртгэлийн санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Ж.Алдаржавхлан гишүүн байна. Ц.Сандаг-Очир гишүүн гараад явчихсан юм уу? Х.Тэмүүжин гишүүн гараад явчихсан. М.Нарантуяа-Нара гишүүн, Д.Энхтуяа гишүүн.

Санал хураалт. Тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. /алх цохив/

11 гишүүн дэмжиж, тогтоол батлагдлаа.

Протоколд тэмдэглүүлэхээр Б.Энхбаяр гишүүн, Ж.Алдаржавхлан гишүүн, Д.Энхтуяа гишүүн, Г.Очирбат гишүүн.

Тогтоол батлагдлаа. Өнөөдрийн хэлэлцэх асуудал дууслаа. Ажлын хэсэгт амжилт хүсье.

Ажлын хэсгийн саналыг хоёр Байнгын хороо хамтарсан байдлаар хэлэлцэнэ. /алх цохив/

15.00 цагаас “Үндсэн хууль” танхимд ажлын хэсэг хуралтай шүү.

Хуралдаан 22 минут үргэлжилж, 13 цаг 56 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**ЦАЛТАН-ОД**